

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 04 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.04

ДНБ-ий өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)

2.4 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 4 дүгээр сар)

5,135 сая \$

Инфляц

(2025 оны 4 дүгээр сар)

8.6 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 4 дүгээр сар)

-58 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 4 дүгээр сар)

4,243 сая \$

Импорт

(2025 оны 4 дүгээр сар)

3,559 сая \$

ГШХО

(2024 он)

4,005 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 3 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 1 дүгээр улирал)

1.38 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.0 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 он)

2.9 хувь

*ХҮИ 2020=100.

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)


5.8 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьд хүрч удааширлаа. Үйлчилгээний салбарууд болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт өсөлтийг дэмжсэн бол барилга, худалдаа, тээвэр, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж өсөлтийг сааруулав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(салбараар)

	2024I	2025I
ДНБ	7.9%	2.4%
Хөдөө аж ахуй	-24.8%	35.6%
Уул уурхай	13.3%	0.8%
Боловсруулах	4.9%	3.7%
Цахилгаан, ус	7.7%	5.5%
Барилга	27.7%	-1.1%
Бөөний болон жижиглэн худалдаа	6.0%	-5.8%
Тээвэр	26.9%	-21.6%
Мэдээлэл, холбоо	27.5%	16.5%
Үйлчилгээний бусад	3.4%	7.1%
Цэвэр татвар	13.1%	-2.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 оны эхний улиралд **2.4 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар тэлж, өсөлтийн 1.0 нэгж хувийг, уул уурхайн салбар 0.8 хувиар тэлж, өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 3.9 хувиар өсөж өсөлтийн 0.4 нэгж хувийг,
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 2.2 хувиар өсөж, өсөлтийн 1.2 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 2.3 хувиар агшиж, өсөлтийг 0.4 нэгж хувиар бууруулав.
- Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон үйлчилгээний бусад салбарын өсөлт голлон нөлөөлөв.
- Уул уурхай, боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Харин өмнөх оны суурийн нөлөөгөөр барилгын салбарын бүтээн байгуулалт буурсан бол нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар тээврийн салбар агшив.
- Мөн хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурч, худалдааны борлуулалт агшив.
- Уул уурхайн салбар 2025 оны эхний улиралд 0.8 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 448 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин нүүрс, алт, газрын тос, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 оны эхний улиралд буурсан байна.
- Тухайлбал, нүүрс олборлолт 20 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар, төмрийн хүдэр 4 хувиар, газрын тос олборлолт 12 хувиар, алт олборлолт 9 хувиар тус тус буурав.
- ХАА-н салбар 2025 оны эхний улиралд 35.6 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 6.2 сая толгой малаар буурснаар сүүлийн 2 жил дараалан агшсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.

1.2 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)2025 оны 1 дүгээр улирал

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны эхний улиралд 51.2 хувь болж, 2 улирал дараалан буурлаа.

PMI
(50=өөрчлөлтгүй)

Тайлбар	2021	2022	2023	2024	2025
Үйлдвэрлэл	48.5	52.1	54.3	58.7	51.2

Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50=өөрчлөлтгүй)

Тайлбар	2021	2022	2023	2024	2025
Аж үйлдвэр	40.2	58.1	59.5	62.3	54.5
Барилга	35.1	45.2	48.3	51.4	52.1
Дотоод худалдаа	38.9	49.1	52.3	55.4	41.3
Үйлчилгээ	32.5	42.1	45.2	48.3	30.2

Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуй нэгжийн төрлөөр
(50=өөрчлөлтгүй)

Тайлбар	2021	2022	2023	2024	2025
Том	35.1	50.2	55.3	58.4	53.9
Дунд	32.5	45.1	48.2	51.3	44.6
Жижиг	30.2	42.1	45.2	48.3	39.4

Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50=өөрчлөлтгүй)

Тайлбар	2021	2022	2023	2024	2025
Шинэ захиалга	45.1	55.2	58.3	61.4	54.5
Үйлдвэрлэл	40.2	50.1	53.2	56.3	48.4
Ажил эрхлэлт	35.1	45.2	48.3	51.4	44.5
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	30.2	40.1	43.2	46.3	39.4
Түүхий эд материалын нөөц	25.1	35.2	38.3	41.4	34.5

Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 1 дүгээр улиралд 51.2 хувь болж, өмнөх улирлаас 7.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар тус тус доогуур гарлаа.

- Сүүлийн 3 жилийн хандлагаар барилгаас бусад салбарын PMI эхний улиралд буурч байсан бол 2025 оны эхний улиралд бүх салбарын PMI буурлаа.
- Барилгын салбарын PMI хамгийн ихээр буюу 17.6 нэгж хувиар унаж, 7 дахь улиралдаа сөрөг хүлээлттэй байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар эерэг хүлээлтээ хадгалсан бол худалдаа эрхлэгчдийн итгэл сөрөг төлөвт шилжсэн байна.


- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 53.9 хувь болж, өмнөх улирлаас 9.3 нэгж хувийн огцом бууралт үзүүлэв.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 5.5 нэгж хувиар буурч 44.6 хувь болсноор эргэн сөрөг төлөвт шилжив.
- Жижиг бизнесүүдийн PMI 6.5 нэгж хувиар буурч, 17 улирлын турш сөрөг хүлээлттэй байна.

- Хөдөлмөр эрхлэлтээс бусад бизнесийн үйл ажиллагааны хүлээлт өмнөх улирлын түвшнээс буурсан хэдий ч нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаанаас бусад хүлээлт эерэг хүлээлтийн бүсэд хадгалагдаж байна.
- Үйлдвэрлэлийн хэмжээний PMI өмнөх улиралд 8.8 нэгж хувиар буурсан бол энэ улиралд дахин 10.6 нэгж хувиар уналаа.




Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 оны эхний улиралд 2.4 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжсэн бол гадаад эрэлт өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төрийн болон өрхийн хэрэглээний өсөлт
(жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 9.9 нэгж хувийг үндсэн хөрөнгө, 9.6 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин цэвэр экспорт өсөлтийг 14.9 нэгж хувиар бууруулсны 11.6 нэгж хувийг экспортын бууралт, 3.3 нэгж хувийг импортын өсөлт бүрдүүлсэн байна.
- Төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурсан бол өрхийн хэрэглээ 11.9 хувиар өсөв.
- Үндсэн хөрөнгийн хуримтлал 30.4 хувиар өсөхөд малын зүй бус хоргодол 6.2 сая толгойгоор буурч, биологийн өсөж үрждэг хөрөнгийн нөөц нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 18 хувиар буурсан бол бараа, үйлчилгээний импорт 2.9 хувиар өслөө.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сард 18 хувиар өсөж, өсөлтийн хурд сүүлийн сард эрчимжив. Уул уурхайн салбарт зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүн буюу нүүрс, төмрийн хүдэр, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурав.



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сард 10.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18 хувиар өссөн байна.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэлийн нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 20.4 хувиар нэмэгдлээ.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний 4 сард 5.9 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл болон химийн бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
 - Нүүрсний олборлолт 2025 оны эхний 4 сард 28.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар буурсан байна. 4 дүгээр сарын дүнгээр нүүрс олборлолт 1.7 хувиар өсөлттэй байна.
- *2024 оны байдлаар


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)

	ӨМНӨХ ОНООС ӨӨРЧЛӨЛТ:
Зэсийн баяжмал	616 мян.тонн 28%
Газрын тос	1.3 сая баррель -12%
Алт	2.5 тонн -15%
Төмрийн хүдэр	2.3 сая.тонн -2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний 4 сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 28 хувиар өсөж 616 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 2.3 сая тоннд хүрч, 2 хувиар буурсан байна. Харин 4 дүгээр сарын дүнгээр 2 хувийн өсөлттэй байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур хэвээр байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн байна.
- Үнэ өссөн:
- Металлын хүдэр олборлолт 24.1 хувиар;
 - Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.6 хувиар;
 - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.1;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 66.8 хувиар тус тус өссөн бол
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 17.8 хувиар;
 - Газрын тос олборлолт 19.6 хувиар
 - Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 1.4 хувиар тус тус буурсан байна.




Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сард үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 0.7 хувиар буурав. Хөдөө аж ахуйн гаралтай мах, арьс шир, ноолуур, гурил зэрэг бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн биет хэмжээ буурлаа.



- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 4 сард 10 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурлаа.
- Махны биет хэмжээний бууралтын нөлөөгөөр 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буураад байна.




- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 52.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар буурлаа.



- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 183 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурлаа*.


*Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн бууралтын нөлөө.



- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сард 133 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурлаа.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээний буурсан хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 20.4 хувиар өссөн байна.

Барилгын салбарын дотоодын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент болон вакум цонх, хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, метал бэлдэц, метал цувималын үйлдвэрлэл буурав.


ЦЕМЕНТ
(мян. тонн)



Хугацаа	2023	2024	2025
1	8.0		
2	37.5		
3	87.1		
4			277.9
12	1,714		1,895

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


КАТОДЫН ЗЭС
(тонн)



Хугацаа	2023	2024	2025
1	714		
2	1,351		
3	1,990		
4			2,611
12	6,976		9,661

Эх сурвалж: ЗЭХЯ-ны тооцоолол, УСХ


МЕТАЛ БЭЛДЭЦ, ЦУВИМАЛ
(мян. тонн)



Хугацаа	2023	2024	2025
1	6.3		
2	12.8		
3	19.0		
4			25.4
12	71.0		73.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ВАКУМ ЦОНХ, ХААЛГА
(мян. м2)



Хугацаа	2023	2024	2025
1	1.5		
2	2.5		
3	5.1		
4			7.9
12	43.3		47.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 277.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар өссөн байна.

- Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 2,611 тонн болж, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурлаа.

- Метал бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 25.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурлаа.


- Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 4 сард 7.9 мянган м2 болж, өмнөх оны мөн үеэс 31.5 хувиар өслөө.



2025 оны эхний улиралд авто замын ачаа тээвэр 2 хувиар өссөн байна. Харин төмөр замын ачаа тээвэр эхний 4 сарын байдлаар нүүрс болон газрын тосны олборлолт буурсантай холбоотойгоор 7 хувиар буурав. Худалдан авалтын идэвх саарч, худалдаа, зочид буудал, нийтийн хоолын салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.

ХУДАЛДАА

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)




Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг. Эх сурвалж: ЗЗХЯ-ны тооцоолол, ҮХХ

- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний улиралд нэрлэсэн дүнгээр 14.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 6.3 хувиар буурав.
- Үүнд, хүнсний бус бүтээгдэхүүний худалдааны борлуулалт буурсан нь нөлөөлөв.

ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг. Эх сурвалж: ЗЗХЯ-ны тооцоолол, ҮХХ

- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний улиралд нэрлэсэн дүнгээр 12 хувь болон 10 хувиар тус тус өссөн байна.
- Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 4 хувиар, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 5 хувиар буурсан байна.

ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2024.04	2025.04	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	14.6	13.6	-7%
Уул уурхайн бүт.	10.5	9.6	-9%
Агаар*	2.9	2.9	-1%
	2024.03	2025.03	
Авто зам	17.9	18.2	2%
Уул уурхайн бүт.	17.5	18.2	4%


Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагддаг. Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төмөр замаар 2025 оны эхний 4 сард 13.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурсан байна. Үүнд, нүүрс болон нефтийн бүтээгдэхүүний тээвэр буурсан нь гол нөлөөлөв.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үетэй ойролцоо түвшинд байна.
- Авто замаар 2025 оны эхний улиралд 18.2 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдэв.

*МЯНГАН ТОНН

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

(жуулчдын тоо, мянган хүн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- 2025 оны эхний 4 сард Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 153.8 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.6 хувиар өссөн байна.



2025 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 7.8 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 683 сая ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2025 оны 4 дугаар сард 4,243 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14 хувиар буурлаа.
- Нийт экспортын 94 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 54 хувийг бүрдүүлж байна.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 1,837 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 1,374 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 58 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 281 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4 хувиар буурлаа.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 176 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурлаа.

ИМПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2025 оны 4 дүгээр сарын байдлаар импорт 3,559 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18 хувийг тоног төхөөрөмж, 18 хувийг нефть, 12 хувийг суудлын автомашин эзэлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ИМПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Тоног төхөөрөмжийн импорт 633 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 652 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурлаа.
- Суудлын автомашины импорт 432 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 369 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.9 хувиар өслөө.




2025 оны 4 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 94 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 88 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспорт 2025 оны эхний 4 сард 25.0 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурлаа.



- Зэсийн баяжмалын экспорт 2025 оны эхний 4 сард 649 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 29.9 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспорт 2025 оны эхний 4 сард 2,449 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өслөө.



- Газрын тосны экспорт 2025 оны эхний 4 сард 1,164 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өслөө.

2025 оны эхний 4 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (сая ам.доллар) 134 310 267 62 38 2019 2023 2024 2024-4 2025-4 Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар ■ Малын махны экспорт 2025 оны эхний 4 сард 38 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39 хувиар буурлаа.	АРЬС ШИР (сая ам.доллар) 11.58 2.43 2.35 1.26 0.34 2019 2023 2024 2024-4 2025-4 Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар ■ Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 4 сард 339 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 73 хувиар буурлаа.	НООЛУУР (сая ам.доллар) 329 360 321 37 19 2019 2023 2024 2024-4 2025-4 Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар ■ Ноолуурын экспорт 2025 оны эхний 4 сард 19 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 49 хувиар буурлаа.	НООС (сая ам.доллар) 5.39 10.24 5.50 0.49 0.51 2019 2023 2024 2024-4 2025-4 Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар ■ Ноосны экспорт 2025 оны эхний 4 сард 511 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.
--	--	---	--



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 188 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 22 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 4 дүгээр сарын дунджаар 9,477 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 4 дүгээр дундаж үнэ 99 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Брент газрын тосны 2025 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 63 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурлаа.


4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

2025.04 сар



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 4 сард 2.0 мянган тонн нүүрс, 2.7 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 11.6 мянган тонн жоншны баяжмал, 4.5 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА (сая тонн)




- 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оноос хойш нийт 39.3 сая тонн нүүрс арилжиж, 4.7 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 4 сард 2.0 сая тонн нүүрс борлууллаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




- 2025 оны 4 дүгээр сард нүүрсний дуудах дундаж үнэ 74 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 75 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 4 дүгээр сард хэлцлийн доод үнэ 19 ам.доллар, дээд үнэ 110 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА (мянган тонн)




- 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 5.8 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 390 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 4 сард 2.7 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




- Төмрийн хүдэр болон баяжмалын 4 дүгээр сарын дуудах дундаж үнэ 65 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 66 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 3 дүгээр сард хэлцлийн доод үнэ 58 ам.доллар, дээд үнэ 89 ам.долларт хүрэв.

Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 3 сард 602 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сараас 139 сая ам.доллараар нэмэгдлээ.




- Төлбөрийн тэнцэл 2025 оны 3 дугаар сарын байдлаар 602 сая ам.долларын алдагдалтай байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 422 сая ам.доллараар их, санхүүгийн дансны ашиг 157 сая ам.доллараар бага байна.



- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 4 дүгээр сарын эцэст 5,135 сая ам.доллар болж, өмнөх сараас 139 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 150 сая ам.доллараар тус тус өссөн байна.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 4 дүгээр сард өдөрт дунджаар 3.8 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,571 төгрөгт хүрлээ.




- Төв банк 2025 оны 4 дүгээр сард нийт 694 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Улмаар 2025 оны эхний 4 сарын нийт дуудлага худалдаа 2.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 42.7 хувиар буюу 777 сая ам.доллараар өслөө.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 4 дүгээр сард 8.6 хувьд хүрч, өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурахад хүнс болон автомашины үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар өссөн байна.



- Инфляц 2025 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 8.6 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.3 нэгж хувь (26.5 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.3 нэгж хувь буюу 73.5 хувийг эзэлж байна.



- 2025 оны 4 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.3 хувиар өсөв.
- Үүнд мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 1.8 хувиар, орон сууцны түрээс 4.7 хувиар, нийтийн хоолны үйлчилгээний үнэ 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 4 дүгээр сард суурь инфляц 9.3 хувь гарч, нийт инфляцын 5.7 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар буурсан үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2025 оны 4 дүгээр сард жилийн инфляцын 13.8 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурлаа.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурлаа.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурчээ. Хүнсний үнийн индекс 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



- Хүнсний инфляц 2025 оны 4 дүгээр сард 6.9 хувь болж, нийт инфляцын 1.9 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц саарахад мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт саарсан нь нөлөөлжээ.
- Хүнсний бус инфляц 9.4 хувь болж, нийт инфляцын 6.7 нэгж хувийг бүрдүүллээ. Хүнсний бус инфляц өмнөх сараас буурахад автомашины үнийн өсөлт саарсан нь голчлон нөлөөлсөн байна.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 4 дүгээр сард дунджаар 3,542 төгрөг болж, өмнөх сараас 1.9 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна.



- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байсан бол 2024 оны 2 дугаар хагасаас буурч эхэлсэн.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,233 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч, тогтворжиж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулж байна.




- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 4 дүгээр сард 128.3 болж, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар, өмнөх сараас 1.0 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сард дэлхийн зах зээл дээр үр тариа, мах, сүүн бүтээгдэхүүний үнэ өссөн бол элсэн чихэр, ургамлын тосны үнэ буурсан байна.



Төсвийн орлого 2025 оны эхний 4 сарын байдлаар 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 12.7 хувиар буураад байна. Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс буурахад түүхий эдийн үнийн уналт нөлөөлсөн байна.


ТӨСВИЙН ОРЛОГО
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 12.7 хувиар буурсан байна.
- Дээрх бууралтад ААНОАТ 977 тэрбум төгрөг буюу 35.4 хувиар, нийт АМНАТ-ийн орлого 892 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 50.1 хувиар буурсан нь голлон нөлөөлөөд байна.


ТӨСВИЙН ЗАРЛАГА
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн зарлага 2025 оны 4 дүгээр сард 8.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 964 тэрбум төгрөг буюу 12.7 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалингийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар тус тус өссөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ
(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны оны 4 дүгээр сард 58 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн тэнцэл өмнөх оноос 2.2 их наяд төгрөгөөр буурлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлох нөлөө үзүүллээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)
(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны эцэст 33.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 41.8 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөж, 41.5 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 3 дугаар сард 38.6 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 33.5 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 4 дүгээр сарын эцэст 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 8.6 нэгж хувь, төгрөгийн харилцах 0.6 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 2.3 нэгж хувь, гадаад валютын харилцах -2.7 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 27.1 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар өсөж, өмнөх сараас 0.2 хувиар буурлаа.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар, өмнөх сараас 4.2 хувиар өслөө.



- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны 3 дугаар сарын эцэст 38.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 33.5 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурсан байна.



- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 3 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 3 дугаар сард 11.5 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өслөө.



Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2025 оны 1 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 380 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.0 хувьд хүрлээ.



Өрхийн бодит орлого 8 улирал дараалан өссөн ч өсөлтийн хурд 2025 оны эхний улиралд 5.8 хувьд хүрч саарав.





Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)




- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 18.3 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 7.9 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)




- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 49 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянга, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 109.8 мянган ААН-ийн 94.8 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 92 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС
(улирлаар, 2018=100)




- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 1 дүгээр улиралд 104.4-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 19.6 нэгжээр нэмэгдсэн. Үүнд хэрэглэгчдийн ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь нөлөөллөө.
- Харин эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 0.2 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөлийн хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 1.4 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 4 дүгээр сард 10.2 хувьд хүрч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өслөө.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)



ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 1.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар буурлаа.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(хувь, тухайн сар)




- 2025 оны 3 дугаар сарын байдлаар экспорт 34.6 тэрбум ам.доллар, импорт 22.8 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 11.8 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурлаа.
- Импорт 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өслөө.

ИНФЛЯЦ
(хувь)



- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2025 оны 4 дүгээр сард 10.2 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өссөн байна.
- ОХУ-ын төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)
(нэгж, хувь)



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 4 дүгээр сард 49.3 болж, өмнөх сараас 1.1 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 3 дугаар сарын байдлаар 0.8 хувь болж, өмнөх сараас 0.6 нэгж хувиар өслөө.



БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 5.4 хувиар өслөө. 2025 оны 4 дүгээр сард экспортын өсөлт 8.1 хувьд хүрч, импортын агшилт саарлаа.



- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 5.4 хувиар өслөө.
- Экспортын өсөлт 2025 оны 4 дүгээр сард 8.1 хувьд хүрлээ. 2025 оны эхний 4 сарын байдлаар АНУ руу хийсэн экспорт 2.5 хувиар буураад байна.
- Импортын агшилт 2025 оны 4 дүгээр сард 0.2 хувьд хүрч саарлаа.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2025 оны 4 дүгээр сард 6.1 хувьд хүрч, өмнөх сараас 1.6 нэгж хувиар саарав.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны өсөлт 2025 оны 4 дүгээр сард 5.1 хувь гарлаа.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 4 дүгээр сард өмнөх сартай ижил -0.1 хувь гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 4 дүгээр сард -2.7 хувь гарч, үнийн уналт үргэлжилж байна.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 4 дүгээр сард 49.0 болж, агшилтыг илэрхийлж байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас буурсан ч тэлэлтийг илэрхийлэх 50-аас дээш түвшинд хадгалагдаж байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажиглалт, түүний эдийн нөөц зээг зүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ